

2023 он 12 сар 14 өдөр

Дугаар 23/41

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

### Хөрөнгө шилжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.17, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 сарын 14-ний өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2023 оны 11 сарын 9-ний өдрийн 23/32 тоот ТУЗ-ийн тогтоолыг хүчингүй болгосугай.
2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дараах хөрөнгүүдээр Хөвсгөл ХК-ийг хөрөнгөжүүлсүгэй. Үүнд:
  - Крипто Үндэстэн ХК-ийн 5,854 ширхэг (5.7 хувь) хувьцааг шилжүүлэх үеийн зах зээлийн ханшаар тооцон шилжүүлэх,
  - Даац Инвестмент ХХК-ийн 15,333,001 ширхэг (51 хувь) хувьцааг өртгөөр нь шилжүүлэх,
3. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн холбоотой этгээдүүдийн дараах хөрөнгүүдээр Хөвсгөл ХК-ийг хөрөнгөжүүлсүгэй. Үүнд:
  - Гэр интерьер дизайн ХХК-ийн 1,000 ширхэг (100 хувь) хувьцааг өртгөөр нь шилжүүлэх,
  - ГрэйпСити Монголиа ХХК-ийн 450 ширхэг (45.0 хувь) хувьцааг өртгөөр нь шилжүүлэх.
4. Энэхүү тогтоолд заасан санхүүжилтийг компани авлагаар бүртгэж, авлагаа Хөвсгөл ХК-ийн нэмж гаргах хувьцаагаар солих нөхцөлтэйгөөр бүртгэхийг даалгасугай.
5. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжилтийг олгож, тогтоолын хэрэгжилтийг ханган, Хөвсгөл ХК-тай холбогдох гэрээ хэлцэл байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2023 он 12 сар 14 өдөр

Дугаар 23/42

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

### *МОСТ Финтек ХХК-д хөрөнгө оруулах сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, компанийн дүрмийн холбогдох заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 сарын 14-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. МОСТ Финтек ХХК-ийн IPO-д 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгөөр хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү түгтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б.Золбоо)-д даалгасугай.



2023 он 12 сар 14 өдөр

Дугаар 23/43

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Компанийн 2024 оны төсөв батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76.1.18 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 сарын 14-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2024 оны төсвийг тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б.Золбоо) болон Санхүү эрхэлсэн захирал (Х.Билгүүн) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ГАНХУЯГ